



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/366

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.8-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус XIII дугаар хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Дэлхийн болон Монголын багш нарын өдрийн үйл ажиллагааны зардалд 10.000.000 (араван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 10,000,000 (Арван сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын үйл ажиллагааны болон мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал"-аас гаргаж аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дэмжлэгээр олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зарцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН